

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2023/06

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.VI	2022.VI	2023.V	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	-	-	13.6	-	-	-	7.9% ▲
Инфляц	хувь	10.6	16.1	11.3%	1.0% ▲	-	7.1% ▲	-5.5% ▼ нэгж хувиар
Ажилгүйдлийн түвшин	хувь	-	7.8% 2022 оны У2	6.6% 2023 оны У1	-	1.3% ▲ нэгж хувиар	-	-1.2% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1548.5	-844.0	1395.3	152 ▲	-	-	2392 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3438.26	3124.25	3461.18	22.92 ▼	-	-	314.01 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3290.8	1360.2	2842.9	447.9 ▲	-	-	1930.6 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	29.5	8.1	23.9	30% ▲	-	-	3.6 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	764.3	747.8	630.3	-9% ▼	-	-	2% ▼
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	10%	13%	0%	-	0%	3% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.81	3.09	3.89	2% ▼	-	-	23% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.66%	8.95%	9.66%	-0.54% ▼ нэгж хувиар	-	-	0.30% ▼ нэгж хувиар

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

Жуулчдын тоо нэмэгдэв	Манай улсын хилээр 2023 оны эхний хагас жилд 2 117.7 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 1 542.8 (3.7 дахин) мянгаар нэмэгдсэн байна.
Эдийн засгийн чуулган болов	ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэгдсэн Монголын үндэсний их баяр наадмаар “Монголд зочлох жил”-ийн хүрээнд “Welcome to Mongolia” уриан дор энэ удаагийн эдийн засгийн чуулганыг зохион байгуулж байна. Нийт 2200 орчим төлөөлөгч оролцож байна. Үүнээс гадаадын 500 гаруй нэр хүндтэй зочид Улаанбаатарт хүрэлцэн иржээ.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-д албан ёсны айлчлал хийв	2023/06/26	Монгол, Хятадын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ агуулгаар баяжуулах, хоёр улсын хооронд яриа хэлэлцээний түвшинд байсан бүтээн байгуулалтын төслүүдийг эцэслэн шийдвэрлэх зэрэг өргөн хүрээтэй асуудлуудаар санал солилцов. Замын-Үүд, Эрээний боомтыг 24 цагийн турш ажиллуулж байхаар тохирсон.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 6 дугаар сард 3438.26 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 314.01 төгрөгөөр чангарсан бол, өмнөх сараас 22.92 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 2%-иар буурч, 3.81 тэрбум ам.долларт хүрээд байна.

#### Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 11.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.1 (38.2%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 10.6 их наяд төгрөг болж, 3.2 (44.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний хагас жилд 9.0 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний хагас жилд нийт 143 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11.8 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 4.3 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.6 (27.9%) тэрбум америк доллароор, экспорт 2.3 (42.5%) тэрбум америк доллароор, импорт 325.6 (8.2%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 6 дугаар сард экспорт өмнөх сараас 88.4 (7.4%) сая америк доллароор, импорт 8.6 (1.1%) сая америк доллароор өссөн байна.

#### Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

**Эх сурвалж: Олон улсын валютын сан**

- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N<sup>0</sup>

**Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>**

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 6-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)

2. [Статистикийн бюллетень, 6-р сар 2023 он, Монголбанк](#)

3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)